

БНХАУ-ЫН ӨМӨЗО-Ы АЖ ҮЙЛДВЭРИЙН ХӨГЖЛИЙН ТАЛААР ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ

*Н.Төмөр**

БНХАУ-ын Өвөр Монголын Өртөө Засах Орон /ӨМӨЗО/-ы аж үйлдвэр сүүлийн жилүүдэд нэлээд эрчимтэй хөгжиж ирлээ. 2003 оны нэгдүгээр сард хуралдсан ӨМӨЗО-ы Ардын төлөөлөгчдийн их хурлын 10 дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган дээр ӨМӨЗО-ы дарга Оюунчимэг “Өнгөрсөн таван жилд аж үйлдвэрийн эдийн засаг тогтвортой хурдан хөгжиж, аж үйлдвэрийн нийт нэмүү өртөг 57,1 тэрбум юань болж, жилд дунджаар 11,3%-иар өсчээ. Аж үйлдвэрийн гол бүтээгдэхүүний хэмжээ тогтвортой өсч, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах, эрчим хүч болон түүхий эдийн аж үйлдвэр хурдан хөгжив” гэж тэмдэглэжээ.¹

ӨМӨЗО-ы аж үйлдвэрийн гол салбарын нэг болох Бугатын хар төмөрлөгийн цогцолбор 1959 онд байгуулагдаж, БНХАУ-ын хар төмөрлөгийн томоохон цогцолборын нэг болжээ.² Бугатын хар төмөрлөгийн цогцолборыг байгуулах болсон нь ӨМӨЗО-ы нутаг дэвсгэрт нээгдсэн Баян-Овоогийн холимог төмөрлөгийн уурхайтай салшгүй холбоотой. Бугат хотоос 150 км зайтай орших энэхүү холимог төмөрлөгийн уурхай нь төмөр, газрын ховор төмөрлөг болон ниобий төмөрлөгөөр нэлээд баялаг юм. Баян-Овоогийн төмрийн хүдрийн нөөц нь 1 тэрбум гаруй тонн бөгөөд газрын ховор төмөрлөгийн нөөцөөр дэлхийд нэгдүгээрт, ниобийн нөөцөөр Бразилийн дараа дэлхийд хоёрдугаарт орно. Үүнээс гадна Баян овооны уурхайд фосфор, магни, кали, алт зэрэг 142 төрлийн төмөрлөгийг зохих хэмжээгээр агуулсан байдаг.³

Бугатын хар төмөрлөгийн цогцолбор эдүгээ 38 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргадаг, үндсэн хөрөнгийн хэмжээ 24,6 тэрбум юаньд хүрч, жилд 8 сая тонн төрөл бүрийн ган болд, 3 сая тонн ган болдын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг юм. Үүнээс гадна ӨМӨЗО-ы Улаан хотын төмөрлөгийн үйлдвэр зэрэг орон нутгийн чанартай хар төмөрлөгийн үйлдвэрүүд мөн хөгжлийн зохих түвшинд хүрчээ.⁴

Орчин үеийн нарийн техник технологи бүхий үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд газрын ховор төмөрлөг нэн чухал үүрэг гүйцэтгэдэг билээ.⁵ Одоогийн байдлаар газрын ховор төмөрлөгийн дэлхийн нөөц нь 45 сая орчим тн байгаагаас ӨМӨЗО-ы Баян-Овоогийн нөөц нь 33 сая орчим тн байгаа юм. БНХАУ газрын ховор төмөрлөгийн хүдрийн

*Н.Төмөр - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

дэлхийн олборлолтын нийт хэмжээний гуравны хоёр хувийг эзэлдэг бөгөөд 1999 оны байдлаар Хятад улс 50 мян. тн газрын ховор төмөрлөгийн хүдрийг экспортонд гаргасан нь дэлхийн зах зээлийн нийт хэрэгцээний 88%-ийг хангажээ.⁶ Хөх хот, Бугат хот /газрын ховор төмөрлөг боловсруулах чиглэлээр Бугат хотод нийт 30 үйлдвэр аж ахуйн газар ажилладаг/, Ухай хот, Баян нуур аймаг зэрэг газарт газрын ховор төмөрлөгийн хүдрийг боловсруулан 80 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээг хангахаас гадна Франц, Япон, Герман, АНУ, Австрали зэрэг 20 улс оронд экспортоор гаргадаг.⁷

ӨМӨЗО-ы аж үйлдвэрийн салбаруудаас нүүрсний аж үйлдвэр мөн чухал байр эзэлдэг. ӨМӨЗО-ы Зүүнгарын нүүрсний уурхай одоогийн байдлаар 26,8 тэрбум тонн нөөцтэй. Сүүлийн жилүүдэд Хятад улсад нээгдсэн 5 нүүрсний ил уурхайгаас 4 нь ӨМӨЗО-д орших бөгөөд үүнд дээр дурдсан Зүүнгарын нүүрсний уурхайгаас гадна Хорин голын, Имин голын, Юаньбаошаний уурхай зэрэг 3 нүүрсний уурхай орно. Эдгээр уурхайнууд аль аль нь 5 тэрбум тонноос дээш нөөцтэй.⁸

Ордосын нутаг дэвсгэрт нүүрсний асар их хэмжээний нөөцтэй. Одоогийн байдлаар 124,4 тэрбум тонн нөөцтэй бөгөөд ӨЗО-ы нүүрсний нийт нөөцийн 1/2 хувийг, Хятад улсын нүүрсний нийт нөөцийн 1/6 хувийг эзэлдэг. Ордосын нүүрсний аж үйлдвэрт улсаас 32 тэрбум орчим юаний хөрөнгө оруулалт хийж, Зүүнгарын нүүрсний уурхай, Бугат-Шэньфу чиглэлийн төмөр зам, Даладын дулааны цахилгаан станц зэрэг гол чухал барилга байгууламжийг бүтээн босгож ашиглалтанд оруулав. 2002 оны байдлаар, Ордосын нүүрсний аж үйлдвэр нийт 60 сая тн нүүрс үйлдвэрлэн борлуулж, 2,6 тэрбум орчим юаний эдийн засгийн үр ашиг гаргажээ.⁹

ӨЗО-ы нүүрсний аж үйлдвэрүүд Их зуу аймаг, Хөлөн буйр аймаг, Улаан хад хот, Ухай хот, Шилэн гол хот зэрэг газарт орших бөгөөд эдгээр аж үйлдвэрт түшиглэн тус ӨЗО-ы цахилгаан эрчим хүчний аж үйлдвэр мөн нэлээд сайн хөгжжээ. 1999 оны байдлаар, ӨМӨЗО-д 6000 кВт-аас дээш хүчин чадалтай дулааны цахилгаан станц 54, нийт 8,64 сая кВт эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай байжээ. Цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэхэд дулааны цахилгаан станцаас гадна усан болон салхины цахилгаан станцыг мөн ашиглаж байна. Тухайлбал, Хатан голын¹⁰ Ваньзэячжай хэмээх газарт Усны аж ахуйн яам, Шаньси муж, ӨМӨЗО-ы хамтын хүчээр барьж байгуулсан усан цахилгаан станц 1999 онд 610 сая кВт/цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэжээ.¹¹ ӨЗО-

д салхины хүчийг ашиглан цахилгаан эрчим хүчийг гаргадаг бөгөөд 1999 оны байдлаар 112 салхины цахилгаан хөдөлгүүрээс нийт 91 сая кВт/цаг цахилгаан үйлдвэрлэжээ.¹²

БНХАУ-ын Засгийн газраас явуулж буй Баруун бүс нутгийг нээн хөгжүүлэх бодлогод нийцүүлэн Өвөр Монголын цахилгаан эрчим хүчний байгууллага үйлдвэрлэлээ хөгжүүлэхдээ цахилгаан станцуудыг нэмж байгуулахын зэрэгцээ цахилгаан эрчим хүчний сүлжээг бий болгох, борлуулах зах зээлийг олж авахын төлөө хүчин чармайлт гарган ажиллаж байгаа юм.¹³ “Баруун хэсэг дэх цахилгаан эрчим хүчийг зүүн хэсэгт хүргэх” төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Хөх хотын Тогтохын эрчим хүчний үйлдвэрт 10 тэрбум юаний хөрөнгө оруулалт хийж, Зүүнгарын эрчим хүчний үйлдвэрт 2,5 тэрбум юаний хөрөнгө оруулж хоёр дахь удаагийн өргөтгөл хийхээр болжээ.¹⁴ ӨМӨЗО-ы цахилгаан эрчим хүчний аж үйлдвэрийн хөгжил нь өөртөө засах орны төмөрлөг боловсруулах, химийн аж үйлдвэрүүд, тээвэр харилцааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

ӨЗО-ы аж үйлдвэрийн бас нэг чухал салбар бол газрын тос олборлох, боловсруулах үйлдвэр юм. ӨМӨЗО-ны нутаг дэвсгэрт маш их хэмжээний газрын тосны нөөцтэй бөгөөд одоогийн байдлаар 13 томоохон газрын тос, байгалийн хийн орд газрыг нээн олж 2-3 тэрбум тонн газрын тос, 270-1000 тэрбум шоо метр байгалийн хийг илрүүлжээ.¹⁵ Жилд тус бүр 1 сая тн түүхий газрын тос үйлдвэрлэх хүчин чадалтай Эрээн, Хорчингийн газрын тосны хоёр орд газар эдүгээ үйлдвэрлэл явуулж байгаагаас гадна 1992 ашиглалтанд орсон Хөх хотын газрын тос боловсруулах үйлдвэр нь жилд 1,3 сая тн газрын тос боловсруулах хүчин чадалтай, бензин, дизелийн түлш, мазут, шатдаг хий зэрэг 22 төрлийн газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байна.¹⁶

ӨМӨЗО-ы авто машины үйлдвэр ХХ зууны 80-90-ээд оны үед Германы Benz авто машины пүүсээс техник технологийн иж бүрэн тоног төхөөрөмжийг оруулан жилд 8-20 тонны даац бүхий 6000 ачааны машин үйлдвэрлэх болсноор Хятад улсын хүнд даацын ачааны машин үйлдвэрлэдэг 3 томоохон үйлдвэрүүдийн нэг нь болжээ. Түүнээс гадна Английн TEREX пүүстэй хамтарч 23-100 тонны даац бүхий 7 төрлийн 13 загварын ачааны машин үйлдвэрлэн Хятад улсын уул уурхайн үйлдвэрт нийлүүлэх болов.¹⁷ ӨМӨЗО-д мөн трактор, цахилгаан хөдөлгүүр, трансформатор, токарийн машин, хөдөө аж ахуйд зориулсан бага оворын тээврийн хэрэгсэл үйлдвэрлэдэг байна.

ТАЙЛБАР, ЗҮҮЛТ:

1. Солонго, сэтгүүл, 2003 №3, 6 дахь тал.
2. Автономный район Внутренняя Монголия Китайской Народной Республики, Москва, 1980, стр. 82., Хятад улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орон /1947-1997/, Бээжин, 1997, 63 дахь тал., Өвөр Монголын Өөртөө Засах Орон, УБ., 1998, 40 дэх тал.
3. Хятад улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орон /1947-1997/, Бээжин, 1997, 62-64 дэх тал., Өвөр Монголын их толь бичиг /Нэй мэngu да цыдянь/, Хөх хот, 1991, 246 дахь тал.
4. Хятад улсын Баруун бүс нутаг-Өвөр Монгол, Бээжин, 2001, 65 дахь тал., Хятад улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орон /1947-1997/, Бээжин, 1997, 64 дэх тал.
5. А.И.Бусев, И.П.Ефимов. Химийн тодорхойлолт, ойлголт, нэр томъёо, УБ., 1987, 163 дахь тал. Газрын ховор төмөрлөг гэдэг нэр 18-р зууны эцэс, 19-р зууны эхээр үүссэн. Газрын ховор төмөрлөгт лантан, церий, празеодимий, неодим, прометий, самарий, европий, гадолоний, тербий, диспрозий, гольмий, эрбий, тулий, иттербий, лютеций зэрэг элементүүдийг агуулсан учир техникийн олон салбарт түүнийг хэрэглэдэг. Жишээ нь: радио электроник багажийн үйлдвэр, атомын техник, машины, химийн ба төмөрлөгийн үйлдвэрт хэрэглэхээс гадна шилний үйлдвэрт өргөн хэрэглэдэг. Эдгээр нь шилний тунгалаг шинж чанарыг нэмэгдүүлдэг. Газрын ховор төмөрлөгийг будаг, лакийн үйлдвэрт хэрэглэдэг ба зарим тэсрэмтгий бодис, тусгай чанарын ган болд, хайлш гаргахад ашиглана.
6. Хятад улсын Баруун бүс нутаг-Өвөр Монгол, Бээжин, 2001, 64 дэх тал.
7. China today'99, China Statistics Press, Beijing, 1999, p.146., Хятад улсын Баруун бүс нутаг-Өвөр Монгол, Бээжин, 2001, 65 дахь тал.
8. Хятад улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орон /1947-1997/, Бээжин, 1997, 59-60 дахь тал.
9. Солонго, сэтгүүл, 2003 №6, 17-18 дахь тал.
10. Хуанхэ булюу Хатан голын 840 км нь ӨМӨЗО-ы нутгаар урсдаг юм.
11. Хятад улсын Баруун бүс нутаг-Өвөр Монгол, Бээжин, 2001, 66-67 дахь тал.
12. Мөн тэнд
13. Монгол улс, БНХАУ-ын ӨМӨЗО-ы найрсаг харилцаа, хамтын ажиллагаа. Хөх хот, 2001, 31-32 дахь тал.
14. Монгол, хятадын харилцаа: Нийгэм-эдийн засгийн зарим асуудал /XX зууны 90-ээд он/, УБ., 2001, 176 дахь тал.
15. Хятад улсын Баруун бүс нутаг-Өвөр Монгол, Бээжин, 2001, 68 дахь тал.
16. Хятад улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орон /1947-1997/ Бээжин, 1997, 61-62 дахь тал., Зууны мэдээ, сонин, 2002.01.12. №10 /896/
17. Өвөр Монголын их толь бичиг, Хөх хот, 1991, 506 дахь тал., Хятад улсын Баруун бүс нутаг-Өвөр Монгол, Бээжин, 2001, 67 дахь тал.